

“МАХИМПЭКС” ХК-ИЙН 2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Илтгэгч: Ж.Чинзориг “Махимпэкс” ХК-ийн
ТУЗ-ийн дарга

2017 оны 04 дүгээр сарын 27

Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид, урилгаар оролцож байгаа эрхэм хүндэт зочид та бүхэнд энэ өдрийн мэндийг Махимпэкс ХК-ийн нийт ажилтан, ажилчдын өмнөөс болон хувиасаа хүргэж байгааг хүлээн авна уу.

Махимпэкс ХК-ийн ТУЗ-өөс 2016 онд хийсэн ажлын тайлангаа та бүхэнд танилцуулан хэлэлцүүлж та бүхний гаргасан үнэтэй санал санаачлага, шүүмжлэлийг 2017 оныхоо ажилд тусган хэрэгжүүлэх болно.

Өнгөрсөн онд тайлангийн хурлаар тавьсан зорилтуудыг ханган биелүүлэх зорилгоор бүтээгдэхүүний зах зээлийн судалгаа хийж компанийн хэмжээнд бизнес төлөвлөгөө, техник зохион байгуулалтын төлөвлөгөө гарган ТУЗ-ийн хурлаар батлуулж мөрдөн ажиллаа.

Монгол Улсын зүүн, баруун аймгуудад дэгдсэн шүлхий, цэцэг, мялзан, боом зэрэг малын гоц халдварт өвчлөл мах экспортыг зогсоох нэг шалтгаан болж сүүлийн жилүүдэд махны экспортын хэмжээ буурсан.

ДМАЭМБ-ын 2016 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 24 дүгээр тогтоолд зааснаар Монгол Улс 2016 оны 05 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн “Зүүн өмнөд Ази, БНХАУ-ын шүлхийтэй тэмцэх бүс нутгийн хөтөлбөр”-ийн бүрэн эрхт гишүүн болсон байна.

Тус хөтөлбөрт гишүүнээр элссэнээр манай оронд сүүлийн 20 гаруй жилд удаа дараа гарч байгаа шүлхий үүсгэгчийн удамшлын судалгаа хийх, улмаар өвчин гарч болох хугацаа, үүсгэгчийн хэвшлийг урьдчилан таамаглах, урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэх ялангуяа хил залгаа орших БНХАУ-тай улам нягт хамтран ажиллах боломжийг олгож байна гэж мах үйлдвэрлэгч бид харж байна.

Монгол Улсын хүнсний аж үйлдвэрийн салбарыг олон улсын нийтлэг чиг хандлагатай уялдуулж стандартчилал, итгэмжлэл баталгаажуулалтын талаар үйлдвэрлэгчдэд мэдлэг олгох, мэдээлэл өгөхөд дэмжлэг үзүүлэх зорилгоор Монголын хүнсчдийн холбоо, Стандарт, хэмжил зүйн газартай 2017 оны 2 дугаар сарын 20-нд хамтран ажиллах санамж бичиг байгууллаа. Тус санамж бичигт төрийн болон

төрийн бус байгууллагын хамтын ажиллагаа идэвхжүүлэх, үйлдвэрийн аргаар боловсруулсан бүтээгдэхүүний экспортын хэмжээг нэмэгдүүлэх, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний үйлдвэрлэлд мөрдөх стандарт, техникийн ерөнхий зохицуулалтад нэмэлт өөрчлөлт оруулах , шинэчлэх, санал боловсруулахад хоёр тал хамтарч ажиллахаар тохиролцсон ба дараах чиглэлээр үйл ажиллагааны төлөвлөгөө гаргасан байна. Үүнд:

- Хүнсний стандартыг шинээр боловсруулах, нэмэлт өөрчлөлт оруулах, хянаж шинэчлэхэд үйлдвэрлэгчдийн оролцоо, саналыг нэгтгэх, шаардлагатай тохиолдолд ажлыг хэсгийг байгуулан стандартчиллын зарчмыг ханган ажиллах
- Хүнсний чанар аюулгүй байдлыг хангах, хэрэглэгчийн эрүүл мэндийг хамгаалах талаар төрөөс баримталж байгаа бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд хүнсний аюулгүй сав боодлыг стандартыг боловсруулах ажлыг хамтран гүйцэтгэх
- Хүнсний үйлдвэрүүдийн дэргэдэх лабораториудын чадавхийг дээшлүүлэхэд сургалт, арга зүйгээр дэмжлэг үзүүлэх
- Итгэмжлэгдсэн лабораториудын сорилтын дүнг талууд /үндэсний, гадаад/ харилцан хүлээн зөвшөөрөх тал дээр хамтран ажиллаж хүнсний бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх /ILAC MRA тэмдгийн хэрэглээг дэмжих /

ХХААХҮЯ болон Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Мал эмнэлэг үржлийн газар махны үйлдвэрийн салбарт дараах үйл ажиллагааг хэрэгжүүлж эхэлсэн.

- “Хүн амын хүнсний хангамжийг тогтворжуулах, стратегийн хүнсний нийлүүлэлтийн улирлын хамаарлыг бууруулах зорилгоор” Мах, сүүний анхдугаар аяныг хэрэгжүүлэх
- “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн 2 дахь үе шатны буюу 2016-2021 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа
- Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх (2016-2020 он)

Хиам утлагат бүтээгдэхүүн, хагас боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбарт цаашдаа технологийн шинэчлэл хийж дотоодын хэрэгцээгээ чанартай, олон нэр төрлийн, эрүүл бүтээгдэхүүнээр тасралтгүй хангахаас гадна ОХУ, БНХАУ-д хиам болон дулааны аргаар боловсруулсан бүтээгдэхүүн экспортлох эхлэл тавигдсан байна. ОХУ, БНХАУ-ын мал эмнэлэг, хорио цээрийн албаны мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах чиглэлээр үе шаттай харилцаа тогтоон, шалгалтын явцад гарсан дутагдалтай зүйлийг засч дахин шалгуулах замаар харилцан ойлголцон ажиллаж байна.

Энэ оныг экспортын чиглэлд илүү анхааран ажиллах болно. Өнгөрсөн онд махны үйлдвэрлэлийн экспортыг нэмэгдүүлэх талаар ОХУ, БНХАУ, БНКАУ, ИБНИУ, Кувейт, Азарбейжан зэрэг орны ижил төрлийн бизнесийн байгууллагуудтай холбоо тогтоож гэрээ хийх талаар удаа дараа тохиролцсон боловч ХХААЯ-аас Монгол улсын төвийн бүсийг өвчингүй гэж зарлаагүйгээс манай үйлдвэрт экспортын зөвшөөрөл гараагүй мөн нөгөө талд импортын зөвшөөрөл олгогдохгүй байна

НЭГ. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Монгол улсын Засгийн газрын 2015 оны 492 дугаар тогтоолоор батлагдсан “Мах” хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд Хүнс хөдөө аж ахуйн яамнаас зарласан тендерт шалгаран гэрээгээр хүлээсэн үүргээ амжилттай биелүүлж ажиллалаа.

Тендерт шалгаран дотоодын бэлтгэлд

- Хонины мах 474.0 тонн
- Ямааны мах 485.0 тонн
- Үхрийн мах 757.1 тонн

Бүгд 1716 тонн мах бэлтгэн нөөцлөн 2016 оны хавар зарж борлуулан гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлсэн байна.

Бид ХХААЯ-тай гэрээ хийж 1716 тонн мах бэлтгэснээс гадна хиамын үйлдвэрлэлийн хэрэгцээнд зориулж нийт 1300 тонн мах үйлдвэрийн аргаар бэлтгэсэн байна.

2016 оны 8 дугаар сараас “Малчдыг дэмжих хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх хүрээнд дараах зорилгыг тавьж ажиллаа.

- Махны үнэ ханшийг тогтворжуулах ченжийн дамжлагыг халж үйлдвэртэй шууд малчид өөрсдөө харилцах.
- Нийслэл хотын иргэдийг үйлдвэрийн аргаар боловсруулсан эрүүл махаар хангах
- Өөрийн үйлдвэрийн хэрэгцээг үйлдвэрийн аргаар боловсруулсан эрүүл махаар бүрэн хангах зорилго тавьж 2016 оны 08 дугаар сараас “Малчдыг дэмжих” хөтөлбөрийг санаачлан хэрэгжүүлэв.

Малчдыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд малчдад дараах үйлчилгээг Махимпэкс ЖК үзүүлэн хамтран ажиллаа.

- Малчдаас малын махыг худалдан авах

- Малын махыг үйлдвэрийн орчинд төхөөрөх
- Малын махыг зориулалтын хөргүүртэй агуулахад хадгалах
- Сүлжээ дэлгүүр нийтийн хоолны газруудад зуулчлан борлуулах
- Малын түүхий эд бөөний төвүүдийг ажиллуулах
- Малчдад шаардлагатай үндэсний үйлдвэрийн өргөн хэрэглээний бараагаар махны үнийн дүнгийн тодорхой хувьд нийлүүлэх

Хөтөлбөрийн хүрээнд дараах аймгуудаас мал бэлтгэсэн.

| № | Аймгийн нэр | Малын тоо (толгой) | | | | Нийт (толгой) |
|-------------|-------------|----------------------|-------------|--------------|--------------|---------------|
| | | Адуу | Үхэр | Хонь | Ямаа | |
| 1 | Булган | 26 | 373 | 12245 | 3331 | 15975 |
| 2 | Завхан | - | 321 | 8511 | 2869 | 11701 |
| 3 | Баянхонгор | 215 | 235 | 1994 | 2950 | 5394 |
| 4 | Өвөрхангай | 266 | 335 | 1039 | 1150 | 2790 |
| 5 | Архангай | - | 342 | 275 | 1342 | 1959 |
| 6 | Дундговь | - | 11 | - | 2130 | 2141 |
| 7 | Хөвсгөл | - | - | 916 | 1200 | 2116 |
| 8 | Төв | 28 | 143 | - | 28 | 199 |
| 9 | Сэлэнгэ | - | 240 | 20 | - | 260 |
| НИЙТ | | 535 | 2000 | 25000 | 15000 | 42535 |

БЭЛТГЭСЭН МАЛЫН ДУНДАЖ ЖИН, ХЭМЖЭЭ

Адуу – 150кг болон түүнээс дээш

Үхэр – 150кг

Хонь – 20кг

Ямаа – 18кг

БЭЛТГЭСЭН НИЙТ МАХНЫ ХЭМЖЭЭ

Үхрийн мах – 300тн

Хонины мах – 500тн

Ямааны мах – 270тн

Нийт 1070тн мах бэлтгэсэн.

Хиам болон хагас боловсруулсан бүтээгдэхүүний эрүүл ахуй, чанарыг дээшлүүлэхээр тайлант онд хиам болон утлагат бүтээгдэхүүнд хэрэглэгдэх махны 60 хувийг өөрийн үйлдвэрт бэлтгэсэн махаар хангасан.

Сүүлийн жилүүдэд хиамын чанарыг сайжруулах зорилгоор Европ стандартаар бэлтгэсэн гахайн махаар өөрийн үйлдвэрийг бүрэн ханган ажиллаж байгаагаас гадна уг гахайн махаар 4 төрлийн

бүтээгдэхүүн шинээр хийж хэрэглэгчдэд нийлүүлээд байна. Уг бүтээгдэхүүн нь хэрэглэгчдийн таашаал хүлээж байгааг дурьдахад таатай байна.

Өнөөдрийн байдлаар 20 гаруй нэрийн хиаман бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа бөгөөд тайлант онд шинэ нэр төрлийн Огурцыг, Помидорт, Конъякт хиам, Берлин брэндийн зүсэж савласан 5 төрлийн Сармист, Леонер, Гахайн ХАМ, Тахианы цээж махтай, Зүрхтэй зэрэг бүтээгдэхүүн үйлдвэрлэж хэрэглэгчдийн хүртээл болгосон байна.

Тайлант онд ХБНГУ-ын Multivac компанитай хамтран хиам зүсэж савлах бүрэн автомат шугамыг ашиглалтад оруулж Монголдоо төдийгүй Ази тивд анх удаа савлагч R245, зүсэгч TS500 машиныг суурилуулан, бүтээгдэхүүнээ азот болон нүүрс хүчлийн хийний нийлэмжтэй савлаж эхэллээ. Мөн БНСУ-ын “Бусанг” компанитай хамтран тус цехийн орчны тохижилтыг НАССР стандартад нийцүүлэн гүйцэтгэв. Энэхүү “Берлин брэндийн” савлагааны цехийн нийт хөрөнгө оруулалт нь 3 тэрбум төгрөг болсон ба 5 төрлийн бүтээгдэхүүн зах зээлд амжилттай нэвтэрч хэрэглэгчдийн таашаалд хэдийнээ нийцээд байна. Борлуулалт Авто паркын алба нь борлуулалтын үндсэн тогтолцоонд өөрчлөлт оруулан бүсчилсэн системийг нэвтрүүлэн D-Manager борлуулалтын сүлжээний программыг ашиглан бүрэн шинэчлэлт хийснээр эдийн засгийн хямралтай үед өмнөх онуудаас борлуулалтын хэмжээ 18%-иар өссөн статистик үзүүлэлттэй ажиллаж байна.

Мэргэжилтнүүдийн мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх орчин үеийн техник технологитой танилцуулахаар ХБНГУ, ОХУ, БНСУ зэрэг улсуудад курсэд суралцуулах, үйлдвэрийн дадлага хийж, тоног төхөөрөмжтэй танилцуулах ажлуудыг дэс дараалалтай зохион байгуулан ажиллаж цаашид ч энэхүү ажиллагааг хийж гүйцэтгэх болно. Мөн үйлдвэртээ АНУ, ХБНГУ, Казакстан, БНХАУ, БНСУ, Польш мэргэжилтнүүдийг урин ажиллуулж тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангуулахын зэрэгцээ технологи горимыг баримтлан шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх зэргээр хамтран ажиллаж байна.

Махны үйлдвэрүүдийн тоног төхөөрөмж технологийн дэлхийн чиг хандлагыг тодорхойлдог гурван жилд нэг удаа ХБНГУ-ын Франкфурт хотод зохиогддог Олон улсын нэр хүндтэй IFFA үзэсгэлэнд оролцож өөрийн үйлдвэрийн тоног төхөөрөмжийг байнга шинэчлэж байгаа нь олны талархлыг хүлээж байна.

Мөн тус үзэсгэлэнд Монголын компаниудаас анх удаа оролцож, бүтээгдэхүүнээ өрсөлдүүлэн Монгол махны амт чанар, Монгол технологич ур ухааныг уралдуулан “IFFA-2016” олон улсын үзэсгэлэнгээс “Махмпэкс” ХК-ийн Нүүдэл жерки “Алтан” медаль, Дээдэс бүрэн утлагат хиам “Мөнгөн” медаль тус тус хүртэж мөн л салбартаа анхдагч боллоо.

Шангрила олон улсын сүлжээ зочид буудал, PIZZA HUT, KFC олон улсын сүлжээ түргэн хоолны газруудад 5 нэр төрлийн бүтээгдэхүүн хөгжүүлэн нийлүүлж байна. Мөн CIC Оюу Толгойн ханган нийлүүлэх компанитай хамтран 7 нэр төрлийн бүтээгдэхүүн нийлүүлж байна.

Компанийн нийт ажилчдыг группын амралтанд 50 хувийн хөнгөлттэй үнээр амраасан. Үйлдвэрийн мэргэжлийн онцлогоос шалтгаалж Хужирт рашаан сувилалд 48 хүн амрааснаас тус компанид олон жил үр бүтээлтэй ажилласан өндөр настан 6 хүн амарчээ.

Тайлант онд тус компанид олон жил үр бүтээлтэй ажилласан ажилтнуудаас Аж үйлдвэрийн гавъяат ажилтан цолоор нэг хүн, Монгол Улсын Төрийн дээд “Хөдөлмөрийн гавьяаны улаан туг”-ийн одонгоор хоёр ажилтан, Алтан гадас одонгоор 6 ажилтан, Хөдөлмөрийн хүндэт медалиар 10 ажилтан тус тус шагнагдсан.

Хэрэглэгчийг эрүүл хүнсээр хангах бодлогын дагуу үйлдвэрт HACCP стандартыг нэвтрүүлэх багийг томилон ажиллаж байгаа ба эдгээр хүмүүсийг 20 багц цагийн сургалтанд хамруулан мэдлэг мэдээлэл олгон цаашдын хэрэгжүүлэх ажлын үндсийг тавьсан.

Ажилтнуудын эрүүл мэнд ажиллах таатай нөхцөл бүрдүүлэх ажлын нэг хэсэг болох бялдаржуулах танхим (фитнесс, аэробек, саун) барьж мэргэжлийн багшаар хичээллүүлэн ажиллуулж байна.

ХОЁР. КОМПАНИЙН ЦААШДЫН ЗОРИЛТ

Үйлдвэрлэлийг хөгжүүлэх, хүчин чадлыг нэмэгдүүлэхэд гадаад экспорт гол ач холбогдолтой. Үүний тулд:

- “Малчдыг дэмжих” хөтөлбөрийг жилд 3-4 удаагийн давтамжтай үргэлжлүүлэн үе шаттайгаар зохион байгуулах
- Үйлдвэрийн аргаар бэлтгэсэн шинэ мах, махан бүтээгдэхүүнийг Номин сүлжээ дэлгүүрээр борлуулах, нэрийн барааны дэлгүүрийн тоог нэмэгдүүлэх
- Хиам болон хагас боловсруулсан бүтээгдэхүүнд хэрэглэгдэх махны 80 хувийг өөрийн үйлдвэрт бэлтгэсэн махаар хангана.
- Махыг үйлдвэрийн аргаар боловсруулж эрүүл ахуй чанарын шаардлага хангасан бүтээгдэхүүнийг иргэдэд хүргэх, махыг бүтцээр нь ангилан савлаж худалдахад санаачлага гарган ажиллана.

- БНХАУ-д дулааны аргаар боловсруулсан мах экспортлох ажлыг гол зорилгоо болгож байна.
- Мөн Гаалийн холбооны улсуудад мах экспортлох ажлыг хэрэгжүүлэх ажлыг хийхэд анхаарах болно
- Бодын цехийн өөрчлөлтийг хийж БНХАУ-д адууны мах экспортлоход голлон анхаарал хандуулах болно
- Мөн Исламын Бүгд Найрамдах Иран Улсад мах экспортлож байсан туршлагадаа тулгуурлан энэ онд дахин хонины мах экспортлох зорилт тавьж ажлуудыг үе шаттайгаар хийгээд байна.
- Үйлдвэрийн хойд талын төв замын засварын ажил хийгдэж байгаатай холбогдуулан хашаа руу орц, гарц оруулан, ар талын хашааг өнгө үзэмжтэй, чанартай материалаар хийж гүйцэтгэж харуул хамгаалалт, гэрэлтүүлгийн асуудлыг засаж сайжруулах
- Ажилтан албан хаагчдыг ээлж дараатайгаар мэргэшүүлэх сургалтад тогтмол хамруулах замаар боловсролын түвшинг байнга ахиулан ажиллах. Компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд төлөвлөгөөт ажлуудыг тогтмол хийх.
- Батлагдсан төлөвлөгөөний дагуу үйлдвэрийн техник технологийг шинэчлэх ажлыг цаашид үргэлжлүүлэн хийнэ.

Хувьцаа эзэмшигч та бүхэн Махимпэкс ХК-ийн 2017 оны үйл ажиллагаа, цаашид тавих зорилтод үнэтэй санал гаргана гэдэгт итгэж байна.

Та бүхэнд ажил хөдөлмөрийн амжилт эрүүл энх сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА

2016 ОНД ГАРГАСАН АМЖИЛТААС

- ❖ Эрүүл хүнс-Эрүүл Монгол хүн уриатайгаар
- “УЛААНБААТАР ТҮНШЛЭЛ-2016” үзэсгэлэн худалдаанд ДЭВШИЛТЭД САВЛАГААТАЙ ХҮНС –ээр Берлин брэнд шалгарсан.
НЗДТГ, ХААХҮЯам жил бүр зохион байгуулагддаг “Намрын ногоон өдрүүд-2016” үзэсгэлэн худалдааны ШИЛДГЭЭР шалгарсан.
- ❖ ХБНГУ-ын Франкфурт хотод зохион байгуулагдсан IFFA -2016 Олон улсын үзэсгэлэнд амжилттай оролцож:
 - “Нүүдэл” жерки – **АЛТАН** медаль
 - “Дээдэс” бүтэн утлагат хиам – **МӨНГӨН** медаль тус тус хүртсэн.
- ❖ Монголын хүнсчдийн холбооны нэрэмжит Нийслэл хиамаар АРД ТҮМНИЙ ХҮНС-2017 шагнал хүртсэн.
- ❖ Улаанбаатар түншлэл-2016 үзэсгэлэн худалдааны Олон улсын стандартыг нэвтрүүлэгч брэндээр шалгарсан.
- ❖ “Дэлхийн оюуны өмчийн өдөр” санамж бичиг гарын үсэг зурсан
- ❖ 2016 оны “Оюуны өмчийг” дээдлэгч байгууллага